

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН 2021 ОНЫ ЭХНИЙХАГАС ЖИЛИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1 Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийнталаарх мэдээлэл:

Баруун бүсийн аймгуудыг өндөр илчлэгтэй, чанартай эрчим хүчний нүүрсээр тогтмол хангах. Энэхүү ажлын хүрээнд “Баянтээг” ХК нь 2021 онд борлуулах нүүрсийг 2019 оны хөрс хуулалтаар бэлтгэсэн бөгөөд нүүрсийг 2020 оны 9-р сард Бьюроу веритас инспекшэнь тестин монголиа ХХК-ийн лабораторит нүүрсний шинжилгээг хийлгүүлсэн бөгөөд нүүрснийилчлэгийг 6,200-7,000 ккал илчлэгтэй гэж тодорхойлсон.

Энэ нь “Баянтээг” ХК-ийн нүүрс нь илчлэг өндөртэй, зах зээл дээр өрсөлдөхүйц эрчим хүчний нүүрс болохыг тодорхойлж байгаа юм.

1.2 Үнэт цаас гаргагчийн түүх, тухай зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Баянтээгийн нүүрсний орд нь Өвөрхангай аймгийн баруун өмнө хэсэгт Нарийнтээл сумын нутагт орших бөгөөд аймгийн төвөөс 130 км, Архангай аймгаас 467 км, Баянхонгороос 100 км, Улаанбаатар хотоос 560 км зайд оршино.

1962 онд жилд 25,0 мян,тн нүүрс олборлох хүчин чадлаар байгуулагдаж, 1978 онд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулаар нөөцийг үйлдвэрлэлийн зэрэгт шилжүүлэн 29.6 сая.тн –ийн нөөцтэй гэж тогтоосон. Тус уурхай нь үндсэн 3 цех тасагтай /Захиргаа аж ахуй, Үндсэн үйлдвэр, Туслах үйлдвэр /-ийн нийт 62 ажилчинтай үйл ажиллагаа явуулж байна. Байгуулагдсан цагаас хойш /59 жилийн хугацаанд/ 10008.9 мян.м³ хөрс хуулж, 6209.9 мян.тн нүүрс олборлон борлуулаад байна.

1.3 Компанийн үйл ажиллагаанытайлан

Уулын ажлын тайлан:

Баянтээгийн уурхай 2021 онд 800.0 мян.м³ хөрс хуулж, 200.0 мян.тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажилласан. Хөрс хуулалтанд ЭКГ-5А экскаватор-1ш, HUYNDAI850LC-9S экскаватор-1ш, САМС автосамосвал-2ш, NORD BENZ авто самосвал-4ш, HOWO-60 автосамосвал-2ш, D65E бульдозер-1ш, SD-300 дугуйт ачигч-1ш, Liugong маркийн автогрейдер -1ш зэрэг техник нэг ээлжээр ажиллаж, Хөрс хуулалтыг 49-51, 44-35-р хайгуулын шугам хооронд нийт 374.0 мян.м³ хөрс хуулж, Нүүрс олборлолтыг 38-43-р хайгуулын шугам хооронд нийт 78.8 мян.тн нүүрс олборлон борлуулж хөрс хуулалтын төлөвлөгөөг 46.75% нүүрс борлуулалтын төлөвлөгөөг 39.4%-тай биелүүлсэн.

Хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 1.1

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	Нүүрс гаргалт	мян.тн	200.0	78.8	39,4%
2	Хөрс хуулалт	мян.м ³	800.0	374.0	46,75%
3	Нүүрс борлуулалт	мян.төг	5,272,728	2,077,560.3	39,4%

Нүүрсний үнэ 2018 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн 29000төгрөг /НӨАТ орсон/ болжөөрчлөгдсөн үнээр борлуулагдаж байна.

Нүүрс татан авалт аймгуудаар


Хүснэгт 1.2

№	Аймаг	2021 оны төлөвлөгөө /мян.тн/	2021 эхний хагас жилийн гүйцэтгэл /мян.тн/	Борлуулалтанд эзлэх хувь	Сарын дундаж татан авалт /мян.тн/
1	Архангай	25000	4774.75	6.0%	0,8
2	Баянхонгор	30000	13768.5	17.5%	2,3
3	Өвөрхангай	87000	32793.45	41.6%	5,5
4	Булган	12000	4175.35	5.3%	0,7
5	Улаанбаатар	3000	2265	2.9%	0,3
6	Говь-Алтай	5500	2975.75	3.8%	0,5
7	Дархан	7500	4463.3	5.7%	0,7
8	Завхан	2000	867.15	1.1%	0,1
9	Төв	5000	2320.4	3.0%	0,3
10	Сэлэнгэ	1000	1045.5	1.3%	0,1
11	Хөвсгөл	2000	720.95	0.9%	0,1
12	Эрдэнэт	15000	8360.15	10.6%	1,4
13	Бусад	5000	273.75	0.3%	0,04
	Дүн	200000	78804	100%	

**"Баянтээг" ХК-ийн 1963-2021 он хүртлэх олборлосон нүүрс, хуулсан хөрсийг
графикаар үзүүлэв**

Хүснэгт 1.3


Нүүрсний борлуулалт /мян.тонн/



	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021. 06.30
■ Нүүрсний борлуулалт мян.тонн	55.3	68.9	91.4	104.8	111.5	149.3	160	167.4	210.6	221.9	78.8

Хүснэгт 1.4

Хөрс хуулалт /мян.м³/



	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021.0 6.30
■ Хөрс хуулалт мян.м ³	80.6	143.6	226.6	251.9	319.8	369.3	489.1	477.6	600.8	822.7	374

2. КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2.1 Удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн

Үндсэн 3 цех

1. Захиргаа,борлуулалт
2. Үндсэн үйлдвэр
3. Туслах үйлдвэр Нийт 70 ажилтантай ажиллана.

<u>№</u>	<u>Овог Нэр</u>	<u>Албан тушаал</u>
1	Н.Данзан	Гүйцэтгэх захирал
2	Л.Энх-Отгон	Ерөнхий инженер
3	Ю.Ариунтунгалаг	Ерөнхий санхүүч
4	Э.Лхагвадулам	ХАБЭА-н ажилтан
5	Б.Март	Борлуулалтын ня-бо
6	Б.Лхамсүрэн	Дотоод хяналтын ажилтан

2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

	<u>Овог Нэр</u>	<u>Албан тушаал</u>
1	Ч.Гүнсэнхорол	ТУЗ-ийн дарга
2	М.Нинжбадгар	ТУЗ-ийн гишүүн
3	Ю.Батсайхан	ТУЗ-ийн гишүүн
4	Д.Миеэгомбо	ТУЗ-ийн гишүүн
5	Б.Ичинноров	ТУЗ-ийн гишүүн
6	О.Батсүрэн	ТУЗ-ийн гишүүн
7	Ц.Оюун	ТУЗ-ийн хараат бус гишүүн
8	З.Дашзэвэг	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9	Н.Болдбаатар	ТУЗ-ийн хараат бус гишүүн
10	Б.Март	ТУЗ-ийн нарийн бичиг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн 5 -аас дээс хувь эзэмшигчдийн мэдээлэл

№	Овог Нэр	Эзэмшиж буй хувьцаа
1	Шунхлай групп ХХК	23.54%
2	Төрийн өмч	70.00%

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

2.3 Компани нь 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг батлах,
2. Компани нь 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай
3. Компани нь 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжилтийн тухай
4. Компани нь 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай
5. Компани нь 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож батлах тухай
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшуулал олгох тухай
8. Аудитын хорооны тайлан дүгнэлт хэлэлцэх,
9. Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай

3. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компани 2020 оны үйл ажиллагааны ашгаас 2021 онд нэгж хувьцаанд 100 төгрөг буюу нийт 25,260,800 төгрөг хувиарлах Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг ХЭХурлаар дэмжиж ногдол ашиг хувиарлах шийдвэр гаргасан. Компани 2012 онд 25,0 сая төгрөг, 2013 онд 25,0 сая төгрөг, 2014 онд 25,0 сая төгрөг, 2015 онд 25.0 сая төгрөг, 2016 онд 25,0 сая төгрөг, 2017 онд 25,0 сая төгрөг, 2018 онд 25,0 сая төгрөг, 2019 онд 1,000,000,000 төгрөг, 2020 онд 800,000,000 төгрөгийг ногдол ашигт тус тус хувиарласан.

4. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны эхний хагас жилийн байдлаар 2115,6 сая.төгрөгийн орлого олж, 2232,2 сая төгрөгийн зардал гарган 116,6 сая.төгрөгийн алдагдалтай ажилласан. 2021 оны эхний хагас жилд Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Булган Дархан, Улаанбаатар, Говь-Алтай, Хөвсгөл, Төв, Эрдэнэт, Завхан, Ховд, Увс зэрэг аймгийн байгууллага, иргэдэд нийт 708804 тн нүүрс борлуулж, 73 байгууллагатай гэрээ байгуулан нүүрс борлуулсан байна.

2021 оны эхний хагас жилд Татвар, төлбөр хураамжийн тайлан:

Хүснэгт 1.5

д/д	Татвар хураамжууд	1тн нүүрсэнд ногдуулах татвар	Хэмжих нэгж	Төлсөн татвар /мян.төг/	Тайлбар
1.	НӨАТ	10%	мян.төг	160,000.0	
2.	АМНАТатвар	2.5%	мян.төг	24,438.1	
3.	Лицензийн төлбөр	581.74га	Мян.төг	4217.6	
4.	Хайгуулын нөхөн төлбөр	Жилд 10000	ам.дол	0	
5.	ХХОАТатвар		Мян.төг	47,470.0	
6.	ААНОАтатвар		мян.төг	0	
7.	АТӨЯХТатвар		мян.төг	1,269.5	
8.	Авто-агаарын бохирдол, замын сан болон даатгалын төлбөр		мян.төг	2211,0	
9.	Газрын төлбөр		мян.төг	57,793.0	
10.	Усны төлбөр		мян.төг	0	
11.	ҮХХ-ийн татвар		мян.төг	3,324.7	
12.	Монголын хөрөнгийнбиржийн бүртгэлийн хураамж		мян.төг	1200.0	
	ДҮН			301,923.9	